

БАТЛАВ
ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ
ДАРГА: *С.Н.Б.А.С.* Ч.ЭРДЭНЭ-ОЧИР
2024 оны 04 сарын 19 өдөр

**"ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ ГҮН ӨРМИЙН ХУДАГ ГАРГАХ"
АЖЛЫН ДААЛГАВАР**

2024.04.18

Талын шанд

Тендер шалгаруулалтын нэр: Говь-Алтай аймгийн Чандмань сумд Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах

Захиалагч болон өмчлөгч байгууллага: Говь-Алтай аймгийн Чандмань сумын ЗДТГ

Санхүүжилт: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэнэ.

Төсөвт өртөг: 1 худаг нь 35 сая. Нийт-70 сая

Зориулалт, хүчин чадал: Говь-Алтай аймгийн Чандмань сумд усжуулах, хүн амын унд ахуйд хэрэглэх зориулалтаар 2 ширхэг гүн өрмийн худгийг шинээр гарган усаар хангах

1. Өлзийбулаг багт
2. Эрдэнэ-Уул багт

Гүйцэтгэгч: Гүн өрмийн худаг гаргаж байсан туршлагатай, техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчинтэй байх.

Ажил гүйцэтгэх хугацаа:

2024оны 04 дугаар сарын 18-ны өдрөөс 2024оны 08 дугаар сарын 30-ны өдөр хүртэл


№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Тендерт оролцогчдын санал
1.	<p>Ерөнхий шаардлага</p> <ol style="list-style-type: none">1. Говь-Алтай аймгийн Чандмань сумын Өлзийбулаг, Эрдэнэ-Уул багуудын нутаг дэвсгэрт гүн өрмийн худаг шинээр гаргах ажлыг гүйцэтгэхэд худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2011, худгийн цооногийн хийц, зохиомж, барилгын ажлыг MNS 6088:2010 стандартыг мөрдлөг болгон доорхи нөхцөлийг хангаж ажлыг гүйцэтгэсэн байх.2. Инженерийн хийцтэй худгийн усны шахуурга, шахуургын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар, холбогч хэрэгсэл, дагалдах зүйлсийг иж бүрнээр худгийн цооногт суурилуулна. Худгийн усны шахуурга дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байх.	

2.	Ажилд тавигдах шаардлага	<p>3. Худгийн үзүүлэлт болон өртөгийн мэдээллийг харуулсан гадна хаягийг стандартын дагуу хийж байрлуулна</p> <p>1. Цооног ухах цооногийг тоноглох:</p> <p>1.1 Цооногийн ашиглалтын ундарга: 2м³-3м³ ус өгөх хүчин чадалтай байна. /0,6л-ээс- 1,8л доошгүй байна/</p> <p>1.2 Усан сангийн диаметр 1,5м – ээс багагүй, материал нь бетон болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн байна.</p> <p>1.3 Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15мм-ээс томгүй байна.</p> <p>1.4 Ус өргөх яндангийн диаметр 25мм-ээс багагүй, материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрдсөн хуванцар хоолой ISO / Хүйтний улиралд тэсвэртэй/</p> <p>1.5 Тунгаагуурын гүн 1,5м-ээс багагүй</p> <p>1.6 Худгийн шавхалт хийж цэвэрлэх хугацаа 12 цагаас багагүй байна.</p> <p>1.7 Усны чанарын сорил /лабораторид шинжлүүлж/ авч шинжилгээ хийлгэсэн байна.</p> <p>1.8 Худгийн цооногийг мэрэгч орохооргүй тагаар тоноглох</p> <p>1.9 Худгийн өрөмдлөгийн гүн 80м-120м</p> <p>2. Худгийн мал услах онгоц, талбай барих:</p> <p>2.1 Мал услах онгоцны хэмжээ 8м-ээс багагүй урттай 400 мм-ийн голчтой хагас цилиндр хэлбэртэй /онгоцны дээд ирмэг газраас 50 см өндөр байна/</p> <p>Материал нь цутгамал бетон байна.</p> <p>2.2 Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна.</p> <p>2.3 Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нүх гаргана.</p> <p>2.4 Онгоцны уртын дагуу 2 талдаа 2м өргөнтэй, 10см зузаантай цементээр цутгасан талбай байна</p> <p>2.5 Услах талбайг хийхдээ бетоныг бат бөх хийнэ.</p> <p>2.6 Услах талбай нь мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэхэд тохиромжтой байна.</p> <p>3. Худгийн насос, бага оврын цахилгаан үүсгүүр, цахилгааны утас, хянах самбар:</p>	
----	--------------------------	--	--

		<p>3.1 Насос нь 0,2л/сек-ээс багагүй ус өргөх хүчин чадалтай байх</p> <p>3.2 Цахилгааны утас 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан насосоос хянах самбарт хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/ ус өргөх хананд 2м тутамд хавчиж тогтооно.</p> <p>3.3 Хянах самбар асааж унтраах товчлууртай насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг/улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай байна</p> <p>3.4 Бага оврын цахилгаан үүсгүүр бензинээр ажилладаг, хүчин чадал өндөртэй, техникийн үзүүлэлт, ашиглалтын заавартай байна.</p> <p>4. Худгийн барилга:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хэмжээ 3м x 3м x 2,2м ✓ Материал: Чанарын шаардлага хангасан тоосго болон блок ✓ Ханын зузаан 38 см ✓ Ханыг гадна, дотор талаас нь шавардаж, цагаан өнгөөр будна. ✓ Худгийн дээвэр бага зэргийн налуу, хавтгай оройтой зориулалтын төмрөөр төмөрлөнө. ✓ хаалга бэхэлгээтэй, 3 нугастай, цоожлох цүү цуургатай байна. 	
3.	Цаашид:	<ul style="list-style-type: none"> ✚ Талбайг цэвэрлэх/ өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/ ✚ Эзэмшигч худгийн барилгыг цоожлон ашиглалтын хугацаанд ашиглагч өрх бүрт түлхүүрийг хувиалан өгч худгийг нийт дундаа ашиглана. ✚ Худгийн усны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хариуцан засвар үйлчилгээг ашиглагч өрхүүд дундын хөрөнгөөр гүйцэтгэнэ. 	

БОЛОВСРУУЛСАН:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Б.БОЛОРТУЯА